

**Засгийн газрын үйл ажиллагааны  
2005 оны 1 дүгээр сарын товч мэдээлэл**  
/2004.12.26.-2005.01.25./

### САНХҮҮ, ЭДИЙН ЗАСАГ

Мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, улсын төсвийн улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор 2005 оны төсвийн жилд 80 хүртэл тэрбум төгрөгийн үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай Засгийн газрын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтлоо.

Мод, бут сөөг, үр тарьц, суулгацын импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, түүнчлэн хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлогыг 2008 оны 1 дүгээр сарын 1-нийг хүртэл хугацаанд хүн амын орлогын албан татвараас чөлөөлж байх хуулийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулав. АХБ-ны 37,1 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн гэрээ болон БНСУ-ын Засгийн газрын “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх” тохиролцооны 23,9 сая ам.долларын төслийн талаар Ерөнхий сайдын захирамжаар зээлийн гэрээ болон тохиролцооны төсөлд гарын үсэг зурах эрх олгов.

Нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны доод түвшингээс доогуур өрхийн гурав ба түүнээс дээш 0-18 хүртэл насны хүүхэд бүрт сар тутам 3000 төгрөг олгоход зориулан 2005 оны төсөвт нийтдээ 21 тэрбум төгрөгийг зарцуулахаар тусгасантай холбогдуулан Олон хүүхэдтэйн тэтгэмж олгох журмыг Засгийн газрын тогтоолоор батлуулан санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг орон нутагт шилжүүллээ.

Эдийн засгийн өсөлт зэрэг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн 2004 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр ДНБ-ий өсөлт 10.6 орчим хувь байхаар гарч байна. Энэхүү өсөлтийн 4.4 хувийг хөдөө аж ахуйн салбар, 4.2 хувийг үйлдвэрлэлийн салбар, 2.0 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2004 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсвийн нийт орлого 697.4 тэрбум төгрөгт хүрч орлогын төлөвлөгөө 52.9 тэрбум төгрөг буюу 8.2 хувиар давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 161.6 тэрбум төгрөгөөр буюу 30.2 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага 713.8 тэрбум төгрөг болж төлөвлөгдсөн нийт зарлагын 97.5 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 97.3 тэрбум төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 2004 оны урьдчилсан гүйцэтгэлээр 164.6 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 16.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарах төлөвтэй байна. Урсгал тэнцлийн ашиг ДНБ-ий 9.1 хувьтай, нийт тэнцлийн алдагдал ДНБ-ий 0.9 хувьтай тэнцэхээр байна.

Улсын төсвөөс энэ сард 37.9 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийснээс олон хүүхэдтэйн тэтгэмжид 1680.0 сая төгрөг, халамжийн тэтгэвэрт 798.0 сая төгрөг, тэтгэврийн нөхөн олговорт 151.3 сая төгрөг, тэтгэврийн даатгалын санд 6518.2 сая төгрөг, төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын хураамжид 404.5 төгрөг, цагаатгалын нөхөн олговорт 34.0 сая төгрөг олгосон байна.

Засгийн газар 2004 онд нийт 41.6 тэрбум төгрөгийн үнэт цаасыг арилжаалж, үнэт цаасны үндсэн төлбөрт 109.5 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 3.1 тэрбум төгрөг, нийтдээ 112.6 тэрбум төгрөгийг гэрээний дагуу харилцагч байгууллагад төлж хүлээсэн үүргээ биелүүллээ.

Засгийн газар 2004 онд банкны бүтцийн өөрчлөлтийн 6.0 тэрбум төгрөгийн өрийн бичгийг мөнгөжүүлж, түүний хүүгийн төлбөрт 2.8 тэрбум төгрөг, 2005 оны 1 дүгээр сард өрийн бичгийн үндсэн төлбөрт 4.0 тэрбум төгрөг төлсөн байна. Засгийн газар 2004 онд зээлийн гэрээний дагуу Монголбанкинд 11.7 тэрбум төгрөгийн зээлийг төлж, 105.3 тэрбум төгрөгийн дотоодын зээлийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газар олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудаас 2004 оны урьдчилсан гүйцэтгэлээр 139.6 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаадын зээлийг ашигласан дүн мэдээтэй байна. Мөн урьд онуудад авсан гадаад зээлийн үндсэн төлбөрт 81.6 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 17.7 тэрбум төгрөг, нийт 99.3 тэрбум төгрөг төлж, хугацаа

хэтэрсэн өрийг гадаад болон дотоод талдаа нэмж үүсгээгүй болохоор ОУВС-гийн өмнө хүлээсэн үүрэг амлалт бүрэн хангагдсан байна. Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу тайлант жилд зээлийн үндсэн төлбөрт 2.0 тэрбум, хүүгийн төлбөрт 9.1 тэрбум, бүгд 11.1 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авсан байна.

АХБ-тай байгуулах Зээлийн гэрээ болон АХБ-ны шугамаар “Боловсролын салбарыг хөгжүүлэх III төсөл”-ийг бэлтгэх техник туслалцааны болон “Тээврийн салбарын стратегийг боловсруулах” төслүүдийг эхлүүлэх баримт бичигт Сангийн сайд гарын үсэг зурав. АХБ-ны Техник туслалцааны хүрээнд хэрэгжих “Хотжилт болон орон сууцны салбарын хөгжил” төслийн хүрээнд АХБ-ны ажлын хэсэгтэй Харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулав.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын шугамаар хэрэгжих “Цаг агаарын урьдчилсан мэдээ гаргах, мэдээллийн дүн шинжилгээний боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх” техник хамтын ажиллагааны төслийг эхлүүлэх хоёр талын тохиролцооны протоколд гарын үсэг зурав.

## **ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА**

Аж үйлдвэрийн хөгжлийн баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, анхны хуралдааныг зохион байгуулав.

“Говийн хөгжлийн санаачлага” төсөл боловсруулах ажлын хэсгийн анхны хуралдааныг зохион байгуулж, шинжээчдийн багийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Гол түншүүдтэй /БНХАУ, ОХУ, АНУ, Япон, БНСУ, ЕХ, Төв Ази/ чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах төлөв байдлын тухай төсөл боловсруулаад байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр боловсруулах асуудлаар бизнес эрхлэгчдийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулав.

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд “Оллоо” компаниас зохион байгуулж буй “Үндэсний үйлдвэртэй цагаан сар” аяныг дэмжиж уриалга гаргалаа.

Монгол-Америкийн Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан зөвлөлийн Монголын талын ажлын хэсгийг хуралдуулж, хамтарсан зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгууллаа.

Чехийн Үйлдвэр, худалдааны сайд тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчилж, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар Хэлэлцээр байгуулав.

Туркийн төлөөлөгчидтэй арьс ширний үйлдвэрийн салбарт хамтран ажиллах болон бусад асуудлаар яриа хэлэлцээ хийсэн.

Казахстанаас нефтийн бүтээгдэхүүн импортлох талаарх Тас-Петролиум ХХК-ийн тавьсан саналтай холбогдуулан Казахстаны Эрчим хүчний сайдад захидал явуулаад байна.

## **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН**

### **Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын талаар:**

Монголын багш нарын баярыг тохиолдуулан “Оны тэргүүний багш” шалгаруулах уралдаанд 30 багшийг улсын хэмжээнд сонгон шалгаруулж батламжлал, мөнгөн шагналаар урамшуулав. Мөн монголын багш нарын холбоотой хамтран Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгийн Боловсрол, соёлын газрыг “2004 оны шилдэг байгууллага”-аар шалгаруулан урамшууллаа.

Аймаг, нийслэлийн арга зүйчдэд зориулсан “Бага насны хүүхдийн хөгжлийн асуудал” сургалтын гарын авлагыг CD-д олшруулж, бага насны хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх, монгол ёс заншилтай танилцуулах зорилгоор “Гэрээ барьж сурцгаая” номыг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр хэвлүүлж, аймаг, орон нутгийн цэцэрлэгүүдэд хүргүүллээ.

Нээлттэй мэтгэлцээн ассоциаци, “Идэр” дээд сургуультай хамтран ЕБС-ийн 10 дугаар ангийн сурагчдын дунд “Эрдмийн индэр” уран илтгэгч шалгаруулах уралдааныг зохион байгуулж, 400 гаруй илтгэгчээс шалгарсан 50 илтгэлийг хоёрдугаар шатанд дүгнэв.

### **Мэргэжлийн боловсролын талаар:**

БСШУ-ы сайдын тушаалаар батлагдсан ажлын хэсгүүдийн дүгнэлтэд үндэслэн төрийн бус өмчийн сургалтын зарим байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлаар БСШУ-ы сайдын тушаал гаргалаа.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Энэтхэг улсад суралцах оюутан, магистрантын сонгон шалгаруулалтыг Энэтхэг Улсын ЭСЯ-тай, Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй "Хүний нөөцийг хөгжүүлэх тэтгэлэг" төслийн хүрээнд тус улсын их, дээд сургуулийн магистрантурт суралцах хүмүүсийн англи хэлний шалгалтыг төслийн багтай хамтран зохион байгуулав.

### **Соёл, урлагийн талаар:**

Д.Цэвэгмид агсны мэндэлсний 90 жилийн ойг тэмдэглэх ажлыг хэрэгжүүлж эхэллээ. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, манай улсын ууган гавьяат багш, эрдэмтэн, зохиолч Дондогийн Цэвэгмид агсны гавьяат үйлсийг сурталчлах, залуу үеийнхэнд таниулах, дурсгалыг мөнхжүүлэхэд чиглэгдэж байгаагаараа ач холбогдолтой юм.

Монгол Улсын ерөнхийлөгчийн "Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай", "Уртын дуугаа өвлөн дээдлэх тухай" зарлиг болон "Морин хуур, уртын дууны талаар авах зарим арга хэмжээний тухай БСШУ-ы сайдын тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор "Морин хуур, уртын дуу" Үндэсний хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулав.

Монгол Улсын гавьяат жүжигчин С.Вандан, Д.Дуламсүрэн нарын нэрэмжит хос дуучдын улсын уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд төв, орон нутгаас 30 гаруй хос дуучид оролцож, хослон дуулах урлагийн төрлийг сурталчлах, хөгжүүлэх, дуучдын уран чадварыг дээшлүүлэхэд сайн нөлөө үзүүллээ.

### **Шинжлэх ухаан, технологийн талаар:**

Монголын нууц товчоог Төрийн ордны ёслолын танхимд залах, эхийг хүлээлгэн өгөв.

"Монгол Улсын Үндэсний хөгжлийн хөтөлбөр-2021"-ийн төслийг эмхтгэл хэлбэрээр хэвлүүлэн яам, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал авч байна. Уг хөтөлбөрийг боловсруулах үндэсний хорооны тайлан болон хөтөлбөрийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулна.

Эрдэм шинжилгээний байгууллагаас боловсруулан үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхэд бэлэн болгосон үр дүнгийн судалгааг холбогдох байгууллагуудаас аваад байна. Энэхүү ажил нь улсын захиалгаар хийгдсэн судалгааны ажлын үр дүнгээс үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх боломжтойг нь сонгож бизнесийнхэнтэй хамтран жижиг, дунд үйлдвэр байгуулахад ач холбогдлоо өгнө.

### **ЭРҮҮЛ МЭНД**

Тивийн аварга шалгаруулах чөлөөт бөх, бодибилдинг, олс таталт, өсвөр үеийн хүндийн өргөлтийн болон дэлхийн аварга шалгаруулах самбо бөхийн тэмцээнд амжилт гаргаж медаль хүртсэн 49 тамирчинд 75.1 сая төгрөгийн мөнгөн шагнал олголоо.

Говь-Алтайн Дарви, Хэнтийн Хэрлэн, Баянхонгорын Эрдэнэцогт сумдад гарсан тарваган тахал өвчний голомтыг цомхотгон дарах, халдвар эсэргүүцэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарсан зардал болох 25.7 сая төгрөгийг аймаг, сумын байнгын онцгой комиссын санал болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн холбогдох байгууллагуудад олгохоор шийдвэрлэж, санхүүжилтэд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн төвлөрсөн арга хэмжээний халдварт өвчинтэй тэмцэх улсын фондын 2004 оны төсвөөс гаргахаар болов.

“Эрүүл мэндийн салбарын хөгжил-2” төслийн хүрээнд “Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулахад мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх нь” техник туслалцааны төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг сайжруулахад мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх нь” техник туслалцааны төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг баталж, удирдах хорооны хурлыг улирал тутам хуралдуулан төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж, бодлогын удирдамжаар хангаж ажиллахыг удирдах хорооны даргад даалгав.

Дархлаажуулалт бүхий халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн вакцины сантай хамтран “Аюулгүй дархлаажуулалт” төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төслийн багийг томилж, төслийг 2005 оны 1 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн 6 сарын хугацаанд нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг, Дундговь, Өмнөговь аймагт хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, төслийг хэрэгжүүлэх талаар Дэлхийн вакцины сан, Дархлаажуулалтын байгууллага хоорондын зохицуулах хороотой хамтран ажиллана.

ДОХ, сүрьеэ өвчинтэй тэмцэх үндэсний дэд хөтөлбөрүүд, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төслүүдийн хэрэгжилтийг зохицуулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын тушаалаар Глобаль сангийн ДОХ, сүрьеэтэй тэмцэх төслийн буцалтгүй тусламжийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа 43.5 мянган ам.долларын үнэ бүхий тоног төхөөрөмж 34.4 мянган ам.долларын лабораторийн оношлуур, эмийг ХӨСҮТ, Цусны төв, ДОХ-ын үндэсний сан, Боловсролын хүрээлэн, Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв болон зарим аймгийн Эрүүл мэндийн газарт хуваарилан олгов.

## **НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР**

### **Нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалтын талаар:**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж батлууллаа. Хууль батлагдснаар амьжиргааны түвшингээс доогуур орлоготой 0-18 хүртэл насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн /эх эцэг, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ хүүхэд тус бүрээр тооцож сар бүр 3000 төгрөгийн олон хүүхэдтэйн тэтгэмж авах эрхтэй болж, жилд 127.0 мянган өрхийн 560.0 мянга гаруй хүүхэд уг тэтгэмжид хамрагдаж 21.6 тэрбум төгрөгийг төсвөөс зарцуулах юм. “Олон хүүхэдтэйн тэтгэмж олгох журам” батлах тухай Засгийн газрын тогтоол гаргав. Уг тогтоолын үндэслэн тэтгэмжийн дэвтрийн загвар, тэтгэмж хүсэх өргөдөл, тэтгэмж авах өрхийн хувийн хэргийн маягтуудыг баталж, мөрдүүлэв.

Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлох зорилгоор НҮБХХ, Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд хийгдсэн “Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлж буй өнөөгийн аргачлалыг судлах, хөгжлийн ижил төстэй орнуудтай харьцуулах нь” судалгааны дүнг үндэслэн “Өрхийн амьжиргааг тодорхойлж, баталгаажуулах аргачлал, асуулгын маягт”, “Өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх аргачлал”-ыг баталлаа. Аргачлал нь өрхийн амьжиргааны түвшинг орлого ба зарлагын хэмжээгээр бус амьжиргааны чадавхийг илэрхийлэх орлуулах хэмжээгээр үзүүлэлтээр тодорхойлж байгаагаараа онцлог юм. Аргачлалд өртөг зардал, цаг хугацаа бага шаардах, бодитойгоор үнэлж, дүгнэх бололцоотой, хялбар бөгөөд үр дүн нь иргэдэд ойлгомжтой, бодитой байх зэрэг зарчмуудыг тусгасан болно

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 1995 оноос өмнө хойно тогтоогдсон тэтгэврийн зөрүүг ойртуулах талаар тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг өсгөх итгэлцүүрийг шинэчлэн тогтоон баталж, 2005 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлэхээр болов.

### **Хөдөлмөрийн зах зээлийн бодлого, зохицуулалтын талаар:**

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “Гадаадаас 2005 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай” Засгийн газрын тогтоол гаргав. Тогтоолд дотоодын ажиллах хүчний мэргэжлийн түвшин чадавхи нь шаардлага хангахгүй байгаагийн зэрэгцээ тухайн үйлдвэрлэл нь манай орны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх ач холбогдолтой нэхмэл, оёдол, арьс шир боловсруулах болон гол төлөв улирлын чанартай хийгддэг алт болон бусад үнэт металлын хайгуул олборлолт, газар тариалан, төмөрлөг болон төмөр эдлэл үйлдвэрлэлийн салбарт гадаадаас авах ажиллах хүчний хувь хэмжээг дунджаар 2-3 пунктээр нэмэгдүүлэхээр тусгав.

Засгийн газраас 2005 оныг “Бичил санхүү, жижиг, дунд бизнесийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих үйлчилгээг боловсронгуй болгох зорилгоор “Бичил санхүү, жижиг бизнесийн дэд хөтөлбөр” боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.

“Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2005-2006 оны улсын хэлэлцээр”-т Засгийн газраас баримтлах чиглэлийн төсөл боловсруулж, ХНЗҮХ-ны ээлжит хуралдааныг зохион байгуулж, 2005-2006 оны улсын хэлэлцээрт Засгийн газар, МҮЭХ, МАОЭНХ-ны баримтлах чиглэлийг хэлэлцэж зөвшилцөв.

Мэргэжлийн сургалтын дэд бүтцэд хамрагдаж буй Өвөрхангай аймгийн бүсийн арга зүйн төв, бизнес инкубаторын төвд Модульд суурилсан ур чадварын сургалт зохион байгуулах сургалтыг дакумын арга зүй дээр тулгуурлан зохион байгуулав.

#### Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар:

2004 онд нийгмийн даатгалын тэтгэвэрт 109,4 тэрбум төгрөг олгохоос 109,4 тэрбум төгрөгийн тэтгэврийг хугацаанд нь бүрэн олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод 106,7 тэрбум төгрөг оруулахаас 113,4 тэрбум төгрөг оруулж төлөвлөгөөг 106,3 хувиар биелүүлжээ. 2004 оны шимтгэлийн орлогын төлөвлөгөөг бүх аймгийн нийгмийн даатгалын хэлтэс, Нийслэлийн нийгмийн даатгалын газар бүгд давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын санхүүжилтэд 105,8 тэрбум, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтэд 20,8 тэрбум, тэтгэмжийн даатгалын санхүүжилтэд 4,4 тэрбум, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санхүүжилтэд 3,7 тэрбум, ажилгүйдлийн даатгалын санхүүжилтэд 1,0 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын санхүүжилтэд нийт 135,8 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн авлага 8,2 тэрбум төгрөг байгаагийн 7,8 тэрбум төгрөг нь аж ахуйн нэгж байгууллагаас, 459,3 сая төгрөг нь төсөвт байгууллагаас авах авлага байна.

#### Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн талаар:

2004 оны жилийн эцсийн урьдчилсан дүнгээр нийгмийн халамжийн тэтгэврийг 46568 хүнд олгож, 7.1 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 184378 хүнд олгож, 11.3 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд 26239 хүн хамрагдаж 537,3 сая төгрөг, тахир дутуу иргэнд үзүүлсэн нийгмийн халамжийн үйлчилгээнд 27510 хүн хамрагдаж 1,1 тэрбум төгрөг, ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт үйлчилгээнд 109072 хүн хамрагдаж 2,8 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ. Нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 396327 хүн хамрагдаж 23,7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

#### Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар:

2004 онд нийт хүн ам 2504.0 мянга болсны дотор хөдөлмөрийн насны хүн ам 1488.9 мянга болж өмнөх оноос 103.4 хувиар өсчээ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгэлтэй, идэвхтэй ажил хайж бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 35.6 мянга болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2218 хүнээр буюу 6.6 пунктээр нэмэгджээ.

Хөдөлмөрийн зах зээл дэх ажилгүйчүүдийн хөдөлгөөнийг 2004 оны байдлаар авч үзвэл нийт 58485 ажилгүй иргэд шинээр бүртгүүлж, бүртгэлээс 56189 хасагдсан нь өмнөх оныхтой харьцуулахад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 3887 хүнээр, бүртгэлээс хасагдсан ажилгүй иргэдийн тоо 3981 хүнээр тус тус буурчээ.

## БАЙГАЛЬ ОРЧИН

“Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Ус рашаан ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг тус тус боловсруулан УИХ-д өргөн барьж нэгдсэн чуулганаар хэлэлцүүлээ.

Мод, модон материал, тарьц суулгацын импортыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан УИХ-д өргөн барилаа.

Байгаль орчны сайдын “2005 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг тогтоох тухай”, “Журам, эрхийн загвар батлах тухай” тушаалын дагуу мод бэлтгэлийн төлөвлөгөө, хуваарийг боловсруулан “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх, тээвэрлэх эрхийн бичиг”-ийг 65475 ш хэвлүүлээ.

Улаанбаатар хотын хог хаягдлын төвлөрсөн цэгийн оновчтой байршлыг тогтоох зорилгоор Нийслэлийн Засаг даргын тамгын газартай, “Полиэтилен баглаа боодлын хэрэглээг хязгаарлах” тухай эрх зүйн баримт бичиг боловсруулахаар Гаалийн ерөнхий газартай хамтран ажиллаж байна.

“Тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны нэр, тоог тогтоох тухай” Монгол улсын засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчны сайдын 2005 оны 24-р тушаалаар ан амьтдыг агнах зөвшөөрлийг 57 аж ахуйн нэгжид олгов.

2005 оны 1 дүгээр сард Байгаль орчны шинжилгээний төв лаборатори нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах 4 харуулаас, нийт 196 сорьц авч, хүхэрлэг хий болон азотын давхар исэл гэсэн 2 үзүүлэлтийг шинжлэн тодорхойлов. Шинжилгээний дүнгээс харахад хүхэрлэг хийн дундаж агууламж  $0.027 \text{ мг/м}^3$ , хамгийн их нь  $0.077 \text{ мг/м}^3$  хүрч, нийт ажиглалтын 38 % нь, азотын давхар ислийн дундаж агууламж  $0.032 \text{ мг/м}^3$ , хамгийн их нь  $0.063 \text{ мг/м}^3$ -д хүрч, нийт ажиглалтын 37% нь агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас тус тус давсан байна. Мөн Усны шинжилгээний 12 сорьц, Туул голын дагуу 10 сорьц хүлээн авч гидрохимийн болон бохирдлын үзүүлэлтүүдийг тодорхойлов. Шинжилгээгээр Налайх орчим усан дахь аммоны азот  $\text{NH}_4\text{-N}$  /-ын агууламж, усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас бага зэрэг давсан байна. Хотоос доош цэвэрлэх байгууламжуудын хаягдал Туулын голын устай нийлснээс голын усны хүчилтөрөгчийн хэмжээ багасч их бохирдолттой байна.

Голын усан дахь ахуйн гаралтай органик бодисын бохирдол ихэсч аммоны азот  $\text{NH}_4\text{-N}$  /-ын агууламж усны чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас 16-35 дахин их, нитритын азот  $\text{NO}_2\text{-N}$  /-ын агууламж 1.4-2.5 дахин их, эрдэс фосфор  $\text{P}$  /-ын агууламж 7-17 дахин их, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч  $\text{BXX}_5$  /13.- 33 дахин ихээр тус тус давсан байна.

Үйлдвэрийн хаягдал усны сорьцыг Улаанбаатар хотын дүүрэг дэх таван цэвэрлэх байгууламжийн орох, гарах цэгээс нийт 10 сорьц авч бохирдлын болон химийн задлан шинжилгээ хийв. Шинжилгээний дүнд Цэвэрлэх байгууламжуудаас гарч байгаа ус 40- 79 %-ийн цэвэршилттэй байна. Ялангуяа энэ сард сорьц авах үед Төв цэвэрлэх байгууламжийн ус, 40 %-ийн цэвэршилттэй байсан нь тус цэвэрлэх байгууламж хангалтгүй ажиллаж байгааг харуулж байна.

Орчны цацрагийн хяналтын цэгүүдээс 48 сорьц авч, анхан шатны боловсруулалт хийж үзэхэд, монгол орны фон цацрагийн түвшингээс давсан тохиолдол гараагүй байна.

## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

Ипотекээр баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлийг хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаяр, Монгол банк, Монголын банкуудын холбоо, Хойд Америк – Монголын бизнесийн зөвлөлийн байгууллагатай хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурав.

Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн 2 дахь шатны төслийн ажилтай танилцаж, Барилга хот байгуулалтын сайд Н.Батбаяр АХБ-ын төлөөлөгч Эри Хондотай санамж бичигт гарын үсэг зурав.

Газрын эрхийн бичгээр газар өмчлүүлэх үндэслэл, арга зүйн талаар холбогдох судалгаа, боловсруулалтыг хийж, Эрхийн бичгээр Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн үзэл баримтлалыг боловсрууллаа.

“Дөчин мянган орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон сууцны хорооллын нягтралыг сайжруулах чиглэлээр баригдах 11000 айлын нийтийн орон сууц болон орчин үеийн төлөвлөлт, дизайнаар шинээр барих 14000 айлын нийтийн орон сууцны хорооллын байршил хүчин чадал, гэр хорооллын 15000 айлын цэвэр, бохир усны нэгдсэн болон хэсэгчилсэн систем, төвлөрсөн цахилгаан хангамжинд холбох асуудлыг тогтоогоод байна.

Эрхийн улсын бүртгэлийн албанд бүтцийн өөрчлөлт хийж, нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэх арга замаар бүртгэлийн шат дамжлагыг цөөлөх зорилгоор газрын эрхийн бүртгэлийн мэдээллийн санг үндэсний болон орон нутгийн түвшинд байгуулах хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг ТНБД-ын тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Нийслэлийн 2005 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хүрээнд нийт 131.54 га газрыг орон сууцны зориулалтаар олгохоор тусган хэрэгжүүлж байна.

## ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЧЛАЛ

Япон Улсын ЖАЙКА-гийн Техниз туслалацаагаар хэрэгжүүлэх “Өвсний үндэс” төслийг эхлүүлэх ажлыг зохион байгуулан цаашид ажиллах төлөвлөгөө гарган монголын талаас гарах зардлын төсөв хийгдэж байна.

Кувейтийн №512 Зээлийн үлдэгдэл хөрөнгөөр засварын тоног төхөөрөч худалдан авах бэлтгэл ажлыг хангах хүрээнд тоног төхөөрөмж худалдан авах саналыг боловсруулж Кувейтийн санд хүргүүллээ.

Төрийн өмчит “МИАТ” хувьцаат компанийн өмчийн дийлэнх хувийг буюу 51.0 хувийг Зам тээвэр, аялал жуулчлалын яаманд шилжүүлэх асуудлыг Засгийн газрын хэлэлцүүлэн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд чиглэлийн яам, мэргэжлийн байгууллагын төлөөллийг түлхүү оролцуулах замаар удирдлагаар ханган ажиллахаар шийдвэрлэв.

Агаарын хөлгийн парк шинэчлэлтийн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор агаарын хөлгийг түрээсээр авч ашиглах эрх зүйн болон эдийн засгийн хүндрэлийг арилгах олон улсын зохицуулалтын баримт бичиг болох, 2001 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр баталсан “Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн олон улсын баталгаат эрхийн тухай Конвенц” болон “Агаарын хөлөгт тусгайлан хамаарах Протокол”-д нэгдэн орох бэлтгэл ажлыг хангаж, хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулаад байна.

Аялал жуулчлалын салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр” байгуулах асуудлыг шийдвэрлэв.

ХБНГУ-ын Засгийн газрын KfW банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Орон нутгийн тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх төслийн танилцуулгыг боловсруулж, мэдээлэл хийхийн зэрэгцээ шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжигдэн авто замын салбарт хэрэгжиж буй “Монгол орны эх газрын эрс тэс уур амьсгалтай нөхцөлд асфальтобетон хучилттай авто замын

ашиглалтын хугацааг уртасгах судалгаа"-ны ажлын дунд шатны тайланг бичиж ШУТИС-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж байна.

Байгаль цаг уурын хүндрэлтэй, цасанд хаагдаж боогддог улсын чанартай зам, даваанууд, замын байгууламжуудын бэлэн байдлыг газар дээр нь очиж шалгах, өдөр тутмын мэдээ авч холбогдох арга хэмжээ авч байна.

Нийслэлийн нийтийн тээвэр зохицуулалтын газар, тээврийн үйлчилгээний төвийн удирдлага, мэргэжилтнүүдийг оролцуулан тээврийн хэрэгслийн техникийн хяналтыг үзлэг, оношлогооны үйл ажиллагааг боловсронгуй болгох, цаашид зохион байгуулах арга хэлбэрийн талаар уулзалт ярилцлагыг зохион байгуулж, Улаанбаатар хотод 2004 онд техникийн хяналтын үзлэг, оношлогоонд ороогүй тээврийн хэрэгслийн судалгааг гарган үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглон үзлэг, оношлогоонд хамруулах талаар Нийслэлийн Засаг дарга болон Цагдаагийн ерөнхий гарын даргад албан бичгээр мэдэгдлээ.

Австри Улстай аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Австри-Монголын аялал жуулчлалын экспертүүдийн дугуй ширээний уулзалт ярилцлагыг Вена хотноо зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган уг уулзалтанд Монголын аялал жуулчлалын 5 байгууллага, аялал жуулчлалын мэргэжлийн дээд сургуулийн төлөөлөгчид оролцох болов. Мөн Вена хотноо зохион байгуулагдсан Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт “Зочин” хэлбэрээр нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцож, Монгол орныг сурталчлав.

Япон Улстай хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Япон Улсын Элчин сайдын дэд тэргүүн Шимизү, II нарийн бичгийн дарга Сомэя нартай уулзан Монгол Улсын Засгийн газраас Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2005-2006 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх Аялал жуулчлалын нөөцийг хөгжүүлэх, жуулчдын тоог өсгөхөд байгаль орчин, хүн амд үзүүлэх нөлөөллийн тухай хөгжлийн судалгааны төслийг уламжилж, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов.

Аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Шинэ оны анхны наран мандахыг харах тусгай галт тэрэгний аялал”-ыг төмөр замын аялал жуулчлалын товчоо, Номадик экспедишн, Банзай трэвел компанитай хамтран 3 дахь жилдээ зохион байгууллаа.

2004 онд гадаадаас ирсэн нийт жуулчдын тоо, аялал жуулчлалын салбарын орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад одоо бүртгэгдсэн тоогоор жуулчдын тоо 300537 болсон нь өмнөх оны мөн үеэс 49.4%-аар өсч, аялал жуулчлалын салбарын орлого 253.4 сая ам.доллар болсон нь өмнөх оны мөн үеэс 69.9%-аар өссөн дүн гарч байна.

ХБНГУ-ын сэргээн босголтын банкны зээл, тусламжаар хэрэгжих “Бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлэх” төслийн Тусгай гэрээний нөхцөл бүхий зөвлөхийн гэрээний төслийг хянан үзэж, 18 зүйл бүхий санал, зөвлөмжийг англи хэл дээр боловсруулан, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах санал боловсруулж, Сангийн яаманд хүргүүллээ.

## **ТҮЛШ ЭРЧИМ ХҮЧ**

Гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжаар түлш, эрчим хүчний салбарт 1990 оноос хойш хэрэгжсэн болон хэрэгжүүлж байгаа төслүүдийн үр дүнг нэгтгэн дүгнэлт гаргаж, дүнг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулав.

Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвд “Автотээврийн хэрэгслийг ШШХ-н нэмэлт төхөөрөмжөөр тоноглох үйлчилгээ, ангилал, ерөнхий шаардлага” гэсэн стандартыг Автотээврийн газартай хамтран боловсрууллаа. Мөн “Автомашиньг хийгээр цэнэглэх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн шаардлага” гэсэн стандартыг боловсруулах ажлыг эхлээд байна.

“Дамжуулах сүлжээг шинэчлэх” төслийн санхүүжилтэнд Шведийн ЗГ-ын зээлийн гэрээг байгуулах асуудлыг ЗГ, УИХ-ын 4 байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэн гэрээнд гарын үсэг зурах эрхийг ЗГ-т олгох шийдвэрийг гаргуулав.



Оюутолгойн цахилгаан хангамжийн асуудлаар танилцуулга бэлтгэн ЗГ-ын хуралдаанд танилцуулан түүний дагуу “Тогтвортой байдлын гэрээ”-нд гарын үсэг зурах бэлтгэл ажлыг хангах шийдвэрийг гаргуулаад байна.

Эрчим хүчний хөтөлбөр-1 төслийн Зөвлөхийн нэмэлт гэрээг хэлэлцэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж гэрээг хэлэлцэн байгуулав.

”Эрчим хүчний салбарын нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, шинэчлэх шаардлага” сэдэвт ажлын уулзалт зөвлөгөөн хийсэн.

Багануур, Шарын гол, Шивээ- Овоо зэрэг 25 уурхайн 2005 онд уулын ажлын төлөвлөгөө, Аваар устгах төлөвлөгөө, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг хянав.

Шарын гол ХК-ийн вагон жингийн засварын ажилд хяналт тавьж 2005 оны 1-р сарын 10-нд ашиглалтад оруулсан бөгөөд одоо хэвийн ажиллаж байна.

Төвийн бүсийн нүүрсний уурхайнууд, ДЦС-уудтай үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааны нөхцлийг хангах, нүүрсний нөөц бэлтгэх зэрэг асуудлаар байнгын холбоотой байж, удирдамж чиглэл өгч ажиллалаа.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний зөвлөгөөн зохион байгуулж, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр /2005-2010/, СЭХ-ийг ашиглахыг дэмжих хуулийн төслийг хэлэлцэж зөвлөмж гаргав.

Дөргөн, Тайширын УЦС-ын ажлын явц байдлыг СЗХурлаар хэлэлцэв. Завхан аймгийн Богдын голын УЦС-ын сувгийг шинэчлэх гэрээний санамж бичгийг ХБНГУ-ын төслийн зөвлөх, ЭХСХТөвтэй хамтран боловсруулж гарын үсэг зурлаа.

ТЭХ-ний сайд “Айванхоу Майнз” компанийн удирдлагууд, Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Саха Дейван Меянатан, АНУ-ын ОУ-ын Хөгжлийн Агентлагийн “Эдийн засгийн бодлогын шинэчлэлт, өрсөлдөх чадвар” төслийн эрчим хүчний зөвлөх Хорст Майнеке, хуулийн зөвлөх Жулиа Уэллер, АНУ-ын Симтек компаний захирал Тэд Свитэн, БНХАУ-ын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Гао Шумао нарыг, ТЭХ-ний дэд сайд ЖАЙКА олон улсын байгууллага, Туркийн барилгын “Айданауэр” компанийн төлөөлөгчид, Италийн эрчим хүчний кабелийн “Пиррелли” компанийн төлөөлөгчид, ТНБД-ын сэргээгдэх эрчим хүчний төслийн удирдагч доктор У.Фрингс нарыг хүлээн авч уулзан санал солилцлоо.

## **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ**

“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч”-ийг шалгарууллаа.

“Фермерийн аж ахуйн тухай” хуулийн үзэл баримтлалыг боловсруулав.

АХБ-ны “Хөдөө аж ахуйн салбарын хөгжил” төслийн хүрээнд худгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн үнэлгээ хийж, дүнг тендерийн хороогоор хэлэлцүүлэв.

Францын тусламжийн улаан буудай хүлээн авахтай холбогдсон гааль, худалдааны татвараас чөлөөлөх, чанарын баталгаажуулалт хийлгэх, хөндлөнгийн болон гааль, хорио цээрийн хяналт хийлгэх арга хэмжээг зохицуулж, эхний ээлжийн 10 вагон улаан буудайг “Алтан тариа” ХК-д хүлээлгэн өгөв. Мөн Япон Улсын тусламжийн улаанбуудайн үнэ тогтоох, хөрөнгө төвлөрүүлэх тухай төсөл боловсруулж, БНХАУ-ын тусламжийн улаанбуудай хүлээн авахтай холбоотой бэлтгэл ажлыг зохион байгуулав.

Гамшгаас хамгаалах ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Зам тээвэр, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам хамтран ажлын хэсэг байгуулан, мал өвөлжилт хүндэрч байгаа Хэнтий аймгийн 6 суманд цагийн байдалтай газар дээр нь танилцаж, холбогдох арга хэмжээ авч байна.

“Бод малыг улсын хэмжээнд индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах” журмыг эцэслэн боловсруулав.

“Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2005 оны төлөвлөгөө болон спиртийн үйлдвэрүүдийн 2005 оны борлуулалтын хуваарийг тус тус батлуулав.

Архи, спиртийн үйлдвэрүүдэд хяналтын тоолуур суурилуулах ажлыг хэрэгжүүлэх талаар авч буй арга хэмжээний талаар хэвлэлийн бага хурал хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулах зөвлөлийн удирдамжийг гаргаж батлуулав.

БНЭУ, БНАСАУ, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, Дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа” төслийн ахлагч, “Дэлхийн зөн” ОУБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчдийг ХХАА-н сайд хүлээн авч уулзлаа.

## **БАТЛАН ХАМГААЛАХ**

### **Бодлого төлөвлөлт, гадаад хамтын ажиллагааны чиглэлээр**

“Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Иракийн ажиллагаанд оролцож байгаа цэргийн багийг солих талаар санал боловсруулах, зохицуулах зөвлөлийн хурлыг зохион байгуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Монгол Улс, БНБУ-ын Засгийн газар хоорондын Монгол Улсын БХЯ-д буцалтгүй тусламж үзүүлэх тухай хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлыг хангав.

Батлан хамгаалах салбарын гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу БНХАУ-ын цэргийн төлөөлөгчдийн манай оронд хийсэн ажлын айлчлалыг зохион байгуулан, Иракт үүрэг гүйцэтгэх цэргийн багийн бэлтгэлийг хангах ажил хийгдэж байна.

“Афганистаны армийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд үүрэг гүйцэтгэх сургагч багш нарын 4 дүгээр ээлжийн бүрэлдэхүүний бэлтгэлийг хангаж, 2005 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Афганистан Улсыг зорилоо.

### **Зэвсэгт хүчний сургалт бэлтгэл, бэлэн байдлын талаар**

ЗХЖШ-ын удирдлага энэ сард Зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах, Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтын бэлтгэлийг хангах, зохион байгуулах, ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлага, ажилтнууд, анги, байгууллагуудын захирагч нар төсвийн Ерөнхий менежертэй 2005 онд бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг байгуулах, 2004-2005 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нартай онолын мэдлэгийг батжуулах шатны сургалт, гэрээт цэргийн I, II жилийн цэргийн албан хаагчидтай цэргийн ерөнхий бэлтгэл, мэргэжлийн гүнзгийрүүлсэн сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, салааны жигдрэлтийг хангах сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний статистик судалгаа гаргах, анги, салбаруудын цэргийн албаны зохион байгуулалт, сахилга дэг журмыг дээшлүүлэх зэрэгт гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

“Иракийн эрх чөлөө” Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй манай цэргийн багийн бүрэлдэхүүн “Чарли” баазад, “Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Сургалтын хөдөлгөөнт багийн 3 дахь ээлжийн бүрэлдэхүүн Афганистаны Кабул хотод үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

## **ГАДААД БОДЛОГО**

УИХ-ын дарга Н.Энхбаяр тэргүүтэй төлөөлөгчид ОХУ-д айлчлав. Мөн УИХ-ын дарга Австри, Дани Улсад айлчлав.

Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдорж ХБНГУ-ын Элчин сайд М.Форверк болон “Чингис хаан ба түүний өв” үзэсгэлэнгийн бэлтгэлийг хангах ажлаар Улаанбаатарт ирж

ажилласан Бонн дахь Холбооны Урлаг үзэсгэлэнгийн танхимын захирал В.Якоб нарыг хүлээн авч уулзав.

Улаанбаатарт суугаа ДТГ, Олон улсын байгууллагын тэргүүн нарыг Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар шинэ жилийг тохиолдуулан хүлээн авч, баяр хүргэлээ.

Монгол, Хятадын хилийг хоёр дахь удаагаа хамтран шалгах хамтарсан комиссын төсгөлийн хуралдаан болсноос гадна Монгол, Хятадын хилийн боомтын асуудлаар хятадын талтай ноот харилцан солилцов.

Байгалийн гамшгийн асуудлаар Японы Кобе хотноо болсон олон улсын бага хуралд Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн сайд У.Хүрэлсүх оролцсон.

Олон улсын худалдааны мэдээлэл, хамтын ажиллагааны агентлагт гишүүнээр элсэх Хэлэлцээрт Женевт суугаа Элчин сайд, Байнгын төлөөлөгч гарын үсэг зурж, Хэлэлцээрийг Засгийн газрын тогтоолоор баталсан бөгөөд холбогдох бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэв.

Далайн хүчтэй давалгаа /цунами/-д нэрвэгдсэн орнууд тухайлбал Шри Ланка, Индонези, Энэтхэг, Тайландад Монгол Улсын Засгийн газраас 40 мянган ам.долларын тусламж үзүүлэх тухай асуудлыг боловсруулаад байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНСВУ, БНАЛАУ-д хийсэн айлчлалын үеэр “Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСВУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”, “Монгол Улсын Голомт банк, Вьетнамын Гадаад худалдааны банк хоорондын бизнесийн хамтын ажиллагааны санамж бичиг”, “Монгол Улсын Засгийн газар, БНАЛАУ-ын Засгийн газар хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Улсын Засгийн газар, БНАЛАУ-ын Засгийн газар хооронд ургамал хамгаалал, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг байгуулсан байна.

2004 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Пхеньян хотноо гарын үсэг зурсан “Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан – техникийн хамтын ажиллагааны Монгол Улс, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын зөвлөлдөх комисс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, тогтоол гаргав.

2004 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан “Туркийн олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хөтөлбөр зохицуулалтын төлөөлөгчийн газар байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр”-ийг УИХ соёрхон баталж, хууль гаргалаа.

## **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРЭГ**

Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар батлуулав.

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж, төрийн захиргааны байгууллагууд өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан Засгийн газрын тухай, Авто замын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Харилцаа холбооны тухай, Газрын тухай зэрэг 30 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэв.

“Үлгэрчилсэн дүрэм батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан батлуулж, Дампуурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн амын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн намын тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд Засгийн газрын санал дүгнэлт бэлтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Гамшгаас хамгаалах тухай, Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон ОУ-ын бусад ажиллагаанд оролцуулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Аудитын тухай, төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай зэрэг хуулийн төслийн үзэл баримтлалыг баталлаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

----- о О о -----